Дараах мэдээллүүдийг Япон хэлнээс орчуулсан болно.

**2021 оны 5 сарын 20-ны өдрөөс**

Сэрэмжлүүлгийн түвшин 4

# Гамшгаас хоргодох зааврын дагуу заавал хоргодох

## Гамшгаас хоргодох зөвлөмж зарлахаа больсон

| Сэрэмжлүүлгийн түвшин | | Гамшгаас хоргодох шинэ мэдээ | Гамшгаас хоргодох хуучин мэдээ |
|---|---|---|---|
| 5 | Байгалийн гамшиг үүссэн. Үүсэх аюул нүүрлэсэн | Нэн яаралтай аюулгүй байдлаа хангах ※1 | Байгалийн гамшиг үүссэнталаарх мэдээ (Үүссэн нь тодорхой болмогц зарлана) |
| ~<Сэрэмжлүүлгийн түвшин 4-с өмнө заавал хоргодох>~ | | | |
| 4 | Гамшгийн эрсдэл өндөр | Гамшгаас хоргодох заавар ※2 | ·Гамшгаас хоргодох заавар (яаралтай)<br>·Гамшгаас хоргодох зөвлөмж |
| 3 | Гамшгийн эрсдэлтэй | Өндөр настан зэрэг※3 хүмүүс аюулгүй газарт хоргодох | Гамшгаас хоргодоход бэлдэх · өндөр настнуудыг нүүлгэн шилжүүлж эхлэх |
| 2 | Цаг агаарын байдал хүндэрсэн | Аадар бороо, үер ус, далайн түрлэгийн анхааруулга (Японы Цаг Уурын Агентлаг) | Аадар бороо, үер ус, далайн түрлэгийн анхааруулга (Японы Цаг Уурын Агентлаг) |
| 1 | Цаашид цаг агаарын байдал хүндрэх эрсдэлтэй | Урьдчилан сэргийлэх анхааруулга (Японы Цаг Уурын Агентлаг) | Урьдчилан сэргийлэх анхааруулга (Японы Цаг Уурын Агентлаг) |

Жич 1: Орон нутаг гамшгийн байдлыг бүрэн тогтоох боломжгүй тул сэрэмжлүүлгийн түвшин 5-ыг тухай бүрд зарлах албагүй.

Жич 2: Гамшгаас хоргодох зааврыг өмнө зарладаг байсан гамшгаас хоргодох зөвлөмжтэй ижил нөхцөлд зарлана.

Жич 3: Сэрэмжлүүлгийн түвшин 3 нь өндөр настнаас бусад иргэд ч мөн шаардлагатай тохиолдолд нөхцөл байдалд тохируулан арга хэмжээ авч, гамшгаас хоргодох бэлтгэлээ хангаan, аюултай гэж үзвэл сайн дураараа гамшгаас хоргодох үе юм.

---

**Сэрэмжлүүлгийн түвшин 5 нь аюулгүй газарт хоргодох боломжгүй, амь насанд аюул учрахуйц байдлыг илтгэнэ.**
**Сэрэмжлүүлгийн түвшин 5, нэн яаралтай аюулгүй байдлаа хангахыг зарлах хүртэл хүлээж огтхон ч болохгүй!**

**Гамшгаас хоргодох зөвлөмж зарлахаа больсон.**
**Харин одоо сэрэмжлүүлгийн түвшин 4, гамшгаас хоргодох зааврын дагуу бүгд аюултай газраас хоргодно уу.**

**Хоргодоход хугацаа шаардагдах өндөр настнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд сэрэмжлүүлгийн түвшин 3, өндөр настнууд хоргодох зааврын дагуу аюултай газраас хоргодно уу.**